


Стандарт хэмжил зүйн газрын даргын
2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн
А/202 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН
ХЭМЖИЛ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ**

д/д	Хэмжлийн төрөл, хэмжих хэрэгслийн нэр	Хэмжил зүйн үйл ажиллагааны		Хэмжих хэрэгслийн	
		хамрах хүрээ	хугацаа	зөвшөөрөгдөх алдаа, нарийвчлалын анги	хэмжих хязгаар, хэмжил зүйн бусад үзүүлэлт
Цахилгаан, соронзон хэмжил					
1	Загварын туршилтад тэнцэж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн загварын цахилгааны тоолуур	Засварлах, суурилуулах	5 жил	$\pm (0.2S; 0.5S)$ $\pm (1.0\sim2.5) \%$	220 В; 230 В, 5(100) А (3x220/380) В (5~100) А; 3*57.7/100 В 5(10) А
2	Загварын туршилтад тэнцэж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн загварын гүйдлийн трансформатор			0,5; 0,5S анги	(50~5000) А/ 5А

Бүртгэлийн дугаар 295





СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, "Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэхэд тавих ерөнхий шаардлага" MNS 6358:2023 стандарт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А/96 дугаар тушаал, Хэмжил зүйн бодлогын газрын даргын удирдамжаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэмжил зүйн үйл ажиллагааны чадавхын давтан үнэлгээнд хамрагдаж хангалттай үнэлэгдсэн "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийг нэгдүгээр, "Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийг хоёрдугаар хавсралтад заасан хамрах хүрээ, хугацаанд хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхээр 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд тус тус бүртгэсүгэй.

2. Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудын хэмжил зүйн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хэмжил зүйн бодлогын газар (Д.Нарангэрэл), Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газар (Л.Баярхүү)-т тус тус үүрэг болгосугай.

3. Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай бичгээр мэдэгдэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.УУГАНБАЯР



13221068